

## МОНГОЛ-АМЕРИКИЙН НИЙГЭМЛЭГ

С.Ганболд

1990 оны 5-р сард байгуулагдсан Монгол-Америкийн нийгэмлэг бол үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу бие даан явуулдаг, сайн дурын ашиг орлогын бус олон нийтийн байгууллага юм.

Тус нийгэмлэгийн зорилго нь хоёр орны улсын болон Засгийн газрын бус байгууллага, нийгэмлэг, бүх шатны сургууль, хувь хүн, иргэдийн хоорондын харилцааг хөгжүүлэх Монгол-Америкийн түүх, шинжлэх ухаан, соёл урлагийг харилцан сурталчлах явдал мөн.

Монгол-Америкийн нийгэмлэгээс өнгөрсөн хугацаанд АНУ-ын ЭСЯ-ны болон зарим байгууллагын хүмүүстэй уулзаж, нийгэмлэгийн зорилго, чиглэл, үйл ажиллагаатай танилцуулах, Америкийн ном хэвлэл, гэрэл зураг, зурагт хуудасны үзэсгэлэн гаргах, кино өдөрлөг зохиох, лекц, дугуй ширээний уулзалт ярилцлага явуулах зэрэг ажлуудыг хийж ирлээ. Зарим ажлуудаас дурдвал:

1. АНУ-ын үндэсний баярыг тохиолдуулан Монгол-Америкийн нийгэмлэгийн үйл ажиллагааг сурталчлах "Холын америк ойртож байна" сэдэвт шоу тоглолтыг МҮЭ-ийн соёлын төв оронд зохион байгуулав.

2. Америк тивийг нээсний 500 жилийн ойд зориулан МЭТНО-нд Америкийн мэдээллийн агентлагтай хамтран "Өөрчлөлтийн үр" зурэгт хуудасны үзэсгэлэнг нээн ажиллуулсан. Үзэсгэлэнгийн нээлтэнд Америкийн мэдээллийн агентлагийн төлөөлөгч ноён Жозеф Меллот, МЭТБНХ, Монгол-Америкийн нийгэмлэгийн удирдах хүмүүс оролцлоо.

Монгол-Америкийн нийгэмлэг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Завхан, Өвөрхангай, Төв аймагт салбар зөвлөлтэй.

Нийгэмлэгээс гишүүдийнхээ хүрээнд АНУ-ын Азийн сангаас ирсэн номууд, Америкийн сэтгүүл, товхимол бусад холбогдох мэдээ материал бүхий уншлагын танхим ажиллуулж байна.

Цаашид мөнөө нийгэмлэг үйл ажиллагаагаа улам идэвхжүүлж, Америкийн талын ижил төрлийн болон бусад байгууллага, хувь хүмүүстэй өргөн хэлхээ холбоо тогтоож хамтран ажиллах бодолтой байна.